

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/60 / А/40

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.13 дахь заалт, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга (П.Одонбаатар), Цагдаагийн ерөнхий газрын дарга (Т.Сүхболд), тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх (М.Чинбат), Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Нямгэрэл) нарт даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ

Б.ЖАРГАЛСАЙХАН

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий
прокурорын хамтарсан 2024 оны 03 дугаар сарын 04 нь:
өдрийн А/60 / А/40 дугаар хамтарсан тушаалын
хавсралт

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН НЭР ТӨР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч (цаашид хохирогч гэх)-ийн нэр төр, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж болон энэхүү журмыг баримтлана.

1.3. Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахад хүний эрхийг дээдлэх, хувийн нууцыг хамгаалах, үл ялгаварлан гадуурхах, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд суурилах зарчмыг баримтлана.

1.4. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан нь энэхүү журмыг дагаж мөрдөж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг ханган ажиллана.

1.5. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн хохирогч болсон тохиолдолд энэхүү журмыг баримтлах бөгөөд хохирогчийг өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэлээрээ харилцах боломжоор хангаж, үзүүлэх хамгаалалтын арга хэмжээг түүний сайн мэдэх хэлээр, эсхүл орчуулагчийн тусламжтайгаар тайлбарлаж өгнө.

Хоёр. Хохирогчийг таньж тогтоох

2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, сэжиглэгдэж буй этгээдийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан эсэхээс үл хамаарч хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хохирогчоор тогтооно.

2.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг таньж тогтоох арга хэмжээг авна.

2.3. Хохирогчийг таньж тогтоох ажиллагааг Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2022 оны А/57 тоот тушаалаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх заавар, асуулга”-ын дагуу явуулна.

Гурав. Хохирогчийн нэр төрийг хамгаалах

3.1.Энэ журмын 1.3-т заасан эрх бүхий албан тушаалтан, өмгөөлөгч, хэргийн бусад оролцогч нь хохирогчийн Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд заасан хувийн болон эмзэг мэдээллээс гадна гэмт хэргийн хохирогч болсон тухай мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.

3.2.Насанд хүрсэн хүн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тухайгаа өөрийн гэр бүлийн бусад гишүүнд мэдэгдэхгүй байх хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргаж болно. Хүсэлтийг хүлээн авсан шүүх, прокурор, мөрдөгч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

3.3.Хохирогчийн хувийн нууцлалыг хангах үүднээс төрийн албаны нууцтай танилцах эрх бүхий тагнуул, цагдаа, прокурорын байгууллага, шүүхээс бусад эрх бүхий байгууллагууд нь өөр хоорондоо хохирогчийн хувийн мэдээллийг дамжуулахдаа түүнээс зөвшөөрөл авч, гарын үсэг зуруулна.

3.4.Шүүх хуралдаанд биечлэн оролцож, мэдүүлэг өгөх боломжгүй хохирогчийг мөрдөгчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүх, прокурор дараах арга хэмжээг авна:

3.4.1.прокурор нь шүүх хуралдаанаас өмнө дуу-дүрсний бичлэг ашиглан хохирогчоос мэдүүлэг авахыг мөрдөгчид даалгах;

3.4.2.шүүх хуралдаанд зайнаас /цахимаар/ оролцох боломжийг шүүх хангах;

3.4.3.Энэ журмын 3.4.1-т заасан мэдүүлгийг шүүх хуралдаанд сонсгох, 3.4.2-т заасан шүүх хуралдаанд цахимаар оролцуулж, мэдүүлэг авах үед хохирогчийн дүр төрхийг нууцлах, дуу хоолойны өнгийг өөрчлөх зэргээр мэдээллийн нууцлалыг өндөр хэмжээнд хангаж, хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг авах;

3.4.4.хохирогчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулах тохиолдолд шүүх хуралдаан болох байрны аюулгүй байдлыг хангаж, шүүхийн байр руу орох, гарах гарцын аюулгүй байдлыг нягтлан шалгасан байх.

3.5.Эрх бүхий байгууллага нь хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах зорилгоор зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг солихгүй байхад анхаарна.

3.6.Хохирогчийн хувийн нууцлалыг хангах үүднээс эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй мэдээлэл /овог, нэр, нас, хүйс, мэргэжил, эрхэлж буй ажил, гэрийн болон ажлын газрын хаяг, фото зураг/-ийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түгээх, бусдад тараахыг хориглоно.

Дөрөв.Хохирогчийн аюулгүй байдлыг хангах

4.1.Хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангана.

4.2.Хохирогчийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын арга хэмжээ авахдаа түүний эрүүл мэндийн байдал, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, боловсрол зэргээр ялгаварлан гадуурхахгүй бөгөөд харин дээрх нөхцөл байдалд тохирсон, эрэлт хэрэгцээнд нь тулгуурласан байна.

4.3.Цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар дараах арга хэмжээг авна:

4.3.1.хохирогчид хуульд заасан эрх үүрэг, төрийн болон төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг ойлгомжтой, тодорхой байдлаар тайлбарлан өгөх;

4.3.2.хохирогчид хуулиар хязгаарлалт тогтоосноос бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүр өгч байх;

4.3.3.гэмт хэрэгт холбогдсон этгээдийг сэжигтнээр баривчлан сулласан болон яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгөх;

4.3.4.хохирогчийг тодорхой аюулгүй газарт байх, эсхүл өөр газар нүүхийг зааварчлах, оршин байгаа газраа соливол мэдэгдэхийг даалгах;

4.3.5.хохирогчид эрсдэлийн/ аюулын зэргийн үнэлгээг хийж, эрсдэлтэй гэж үзвэл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан хохирогчийн болон түүний гэр бүлийн бусад гишүүний аюулгүй байдлыг хангах хамгаалалтын арга хэмжээг прокурорын тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн Гэрч хохирогчийг хамгаалах нэгжтэй хамтран хэрэгжүүлэх;

4.3.6.хохирогч хамгаалалтын арга хэмжээ авахаас сайн дураар татгалзсан бол энэ талаар баримтжуулах;

4.3.7.эрсдэлийн үнэлгээ өндөр гарсан болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар хохирогчийг хамгаалах байранд хүргэх;

4.3.8.гэмт үйлдлийн улмаас хохирогчийн амь бие, эрүүл мэндэд халдах талаар үндэслэлтэй мэдээлэл авагдсан тохиолдолд хамгаалалтад авах арга хэмжээг хохирогчийн зөвшөөрөл шаардахгүйгээр зохион байгуулах.

4.4.Прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хохирогчид шаардлагатай дараах мэдээллийг өгнө:

4.4.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, үйл явц;
4.4.2. Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах;

4.4.3. Хохирогчийг болон түүний гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээ;

4.4.4. Хувийн нууцлалаа хангуулах эрх;

4.4.5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл авах эрх;

4.4.6. Хохирогч нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн бол түүний эх хэлээр, эсхүл хамгийн сайн мэддэг хэлээр, эсхүл орчуулагчийг оролцуулан хуульд заасан эрх, үүрэг, оршин суух зөвшөөрөл, орон, оршин суух эрх хүсэхтэй холбоотой зохицуулалт, төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг ойлгомжтой, тодорхой тайлбарлан өгөх.

4.5. Шүүгч, прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.5.1. Хохирогчийг таниулах мэдээллийг нууцлах;

4.5.2. Хэрэгтэй танилцаж хохирогчийн болон гэр бүлийн гишүүний хувийн нууцлалыг хангах шаардлагатай эсэхийг нягтлах;

4.5.3. Хамгаалах байранд байгаа хохирогчтой алья болох уулзахгүй байх, уулзах бол нууц байдалд уулзах;

4.5.4. Шүүх хуралдаан болох байрны аюулгүй байдлын зургаллыг гаргах, шаардлагатай гэж үзвэл шүүх хурлыг өөр байранд хийх санал гаргах.

4.6. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгаалах байр ажиллана. Хамгаалах байртай холбоотой харицлаг тусгайлан журмаар зохицуулна.

Тав. Хохирогч хүүхдийг хамгаалах

5.1. Хүүхэд хохирогч болсон бол Хүн хуралдаалахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар цагдаагийн байгууллага болон энэ хуулийн 9.1-д заасан хамгаалах байрны ажилтан нь түүний эцэг, эхийг олж тогтоох арга хэмжээ авна.

5.2. Хүүхэд хохирогч болсон талаарх мэдээллийг түүний эцэг эхийг олж тогтоомолд мэдэгдэх ба хэрвэ түүнийг хохироо үйлдлийг эцэг эх хийсэн бол хүүхдийг нэн даруй гэр бүлээс нь тусгаарлана.

5.3. Хохирогч хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй болон эцэг эх нь хүн хуралдаалах гэмт хэрэгтэй ямар нэгэн байдалар холбоотой нь мэдэгдсэн бол түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилно.

5.4.Асран хамгаалагч, харгалзан дэмжих этгээд нь хүн худалдаалах гэмт хэрэгт ямар нэгэн хэлбэрээр оролцоогүй байх ба татгалзах ноцтой шалтгаангүй бол хүүхдийг хүлээн авч, аюулгүй байдлыг нь хамгаалахад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

5.5.Хохирогч хүүхдийг энэ журмын 5.2 дугаар зүйлд зааснаар аюулгүй байдлыг хамгаалах ба хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулна.

5.6.Хүүхдэд зориулсан хамгаалах байр нь хүүхдийн нас, тусгай хэрэгцээнд тохирсон, аюулгүй, тохиромжтой сууц байна.

5.7.Хохирогч өөрийгөө хүүхэд гэж үзэж байгаа боловч түүний насыг тодорхойлох баримт бичиг байхгүй тохиолдолд насыг нь тодорхойлох хүртэл түүнийг насанд хүрээгүй хүн гэж тооцож хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Зургаа. Төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагаа

6.1.Төрийн байгууллага нь хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хохирогч төвтэй, хохирогчийн эрх, нэр төрийг хүндэтгэсэн, жендерийн мэдрэмжтэй, хохирогчид учирсан сэтгэцийн гэмтэл, эмгэг зэргийг харгалзан үзсэн арга хандлагыг баримтлах ба дээрх арга хандлагыг төлөвшүүлэх сургалтыг дангаар болон төрийн бус байгууллагатай хамтран байнга зохион байгуулна.

6.2.Төрийн байгууллагууд хохирогчийг таньж тогтоох, тусламж үйлчилгээнд холбон зуучлах, хамгаалах, мэдээллийг дамжуулах, үйлчилгээ үзүүлэх, хувийн нууцлалыг хадгалах зэрэг ажиллагааг цаг алдалгүй, шуурхай, бодитой үзүүлэх талаар хамтран уялдаа холбоотой ажиллана.

6.3.Хохирогчийг таньж тогтоох, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, хамгаалалтын арга хэмжээг шуурхай үзүүлэх цахим флатформыг Цагдаагийн ерөнхий газарт байршуулах ба энэхүү флатформ нь хохирогчийг таньж тогтоох, байгууллага хооронд шуурхай холбоо тогтоох, ажиллагааны бүртгэл-хяналт хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээ, хамгаалалтын арга хэмжээнд хамруулах, тайлан мэдээ гаргах функцтай байна.

Долоо. Санхүүжилт

7.1.Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг холбогдох улс, орон нутгийн төсөв болон бусад санхүүжилтээс санхүүжүүлнэ.

---oOo---